

Завханбаялаг ХК-ний 2015 оны үйл ажиллагааны тайлан

Тус компани нь Завхан аймгийн төв Улиастай сумын Өлзийт багийн нутаг дэвсгэрт байрладаг. Аймгийн төвд 5, Тосонцэнгэл суманд 1 дэлгүүрт бөөний төв, аймгийн 15 сумдад гэрээт дэлгүүр ажиллуулж байна. Мөн Улаанбаатар ,Эрдэнэт Архангай, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай аймагт бага хэмжээний борлуулалт хийж бүтээгдэхүүнээ танилцуулах хэмжээнд ажиллаж байна.

Компани нийт 47 хувьцаа эзэмшигчтэй, бүх хувьцааны 92 хувь нь нэгдмэл сонирхол бүхий 5 хүн эзэмшдэг. Хувьцаа эзэмшигчийн хурлыг 1 удаа , ТУЗ-ийн хурлыг 5 удаа хийж , Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ТУЗ ба түүний эрх олгосноор айуулцэтгэх захирал, компанийн үйл ажиллагааг удирддаг. Компани 2015 оны байдлаар нийт 24 байнгын ажиллагсад 25 гаруй гэрээт ажилчидтайгаар Техник технологийн алба , Санхүү мэдээллийн алба, Марктенг борлуулалтын алба, Дотоодын хяналтын лаборатори гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар хүнсний үйлдвэрлэл худалдааны үйл ажиллагааг явуулж байна.

2015 онд тус компани нв 360,6 сая төгрөгний борлуулалт хийж 7.2 сая төгрөгний ашигтай ажилласан байна.

2015 онд тус компани нь байгалийн зэрлэг жимсийг тариалж 13.0 тн чацаргана хурааж авсан ба мөн нэрс,үхрийн нүд, чонын элэг зэрэг жимс худалдан авч түүнийгээ боловсруулж, жимсний жүүс, чанамал,жимсний дарс, ликёр,чацарганын тос ,чихэр нарийн боов, цэвэр ус, цагаан архи, иоджуулсан давс , ургамлын цай, арц зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хүн амын хүнсний хэрэгцээг хангахад зохих хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Чанарын удирдлагын тогтолцоог улам сайжруулж, дотоодын хяналтын баг тусгай төлөвлөгөө хөтөлбөр гарган ажилласнаар бүтээгдэхүүний чанар сайжирч, чанарын доголдол хэлбэлзэл буурч, чанарын баталгаатай бүтээгдэхүүнийг худалдаанд гаргах ажил хэвшсэн байна.

Бүтээгдэхүүний чанар сайжруулах, нэр төрлийг олшруулах чиглэлээр анхаарч, бүтээгдэхүүний сав баглаанд өөрчлөн шинээр гишүүний чанамал,жимсний цай, хар талх, чацарганатай боов зэрэг бүтээгдэхүүнийг хийж ажилласнаар бүтээгдэхүүний борлуулалт зохих хэмжээгээр өссөн амжилт гаргасан байна.

2015 оны жилийн тайлангийн үзүүлэлтэнд хийсэн дүгнэлт цаашид авах арга хэмжээний санал:

1. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах , дотоод нөөц бололцоог ашиглан шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Үүнд: Нарийн боовны цехийг өргөтгөн зохион байгуулж,шинэ нэрийн нарийн боов талх үйлдвэрлэх техник технологи эзэмшиж, үйлдвэрлэлийг 5-10 дахин нэмэгдүүлэх, мөн дүрдэг цай, чонын элэг,чацаргана жимсний цэвэр жүүсийг тусгай савалгаатай үйлдвэрлэх,жимс ногооны дармал үйлдвэрлэх,шинэ төрлийн чихэр хийх, технологи эзэмших

2. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэх чиглэлээр анхаарч, чихэр нарийн боовны цехид үйлдвэрлэлийн зохистой дадалыг хэвшүүлэхэд анхаарч ажиллах

3. Компанийн удирдлагын орон тоо бүтцийг оновчтой болгож, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж ажиллах
4. Тува улстай шинэ хамтарсан үйлдвэрийн судалгаа хийж хамтран ажиллах, тува улсаас зарим түүхий эдийн хангалтыг хийх ажлыг зохион байгуулах ,гадаад худалдааны гэрээ хэлцэл хийж орос хүнсний барааг зарж борлуулах
5. Улаанбаатар, Эрдэнэт, Архангай, Говь-Алтайд бараа бүтээгдэхүүн борлуулах ажлыг системтэй хийж борлуулалтын ажлыг эрчимжүүлэх,онлайнар бараа түгээх ажил зохион байгуулах
6. ТУЗ ба хянан шалгагчдын удирдан чиглүүлэх үүрэг ролийг нэмэгдүүлэх
7. Газар тариалан туслах аж ахуйн ажлыг эрчимжүүлэх нэмэгдүүлэх ажлыг хийх
8. Шинээр эсгий болон ноосон нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг ажиллуулах
9. Жимс боловсруулах шинэ төсөл хийж тоног төхөөрөмж,сав, баглаа боодол шинчлэн жимсний төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх